

Хүннүгийн зураасан зурагт шинэ олдвор: Их Сансар уулын булшнаас илэрсэн сийлбэр зураг

Энхбаярын Мижиддорж^{1*}, Ганболдын Анхсанаа², Баатарын Галбадрах³

Товч агуулга: Тус өгүүлэлд 2023 онд Монгол Улсын Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Их Сансар уулын “Хар чулуут”-ын хүннүгийн оршуулгын 1-р булшнаас олдсон бүсний арлын дотор талд хурц үзүүртэй зүйлээр нарийн зураас гаргаж зурсан гурван амьтны дүрслэлийг авч үзэв. Шинээр илрүүлсэн богхед бүсний арлын зураасан зургийн дүрслэл нь дайчин эрийн ангийн олз омог, дайн тулааны ялалтыг бэлгэдэж, цаашлаад цэргийн албан тушаал, овгийн бэлгэдэл зэргийг илэрхийлж байгаа бололтой.

Түлхүүр үг: Хүннү булш, богхед, бүсний арал, зураасан зураг

Удиртгал

НТӨ II-I зуунд Хүннүгийн хүчирхэгжилтийн оргил үед төрөл бүрийн материалаар хийсэн тэгш өнцөгт хэлбэртэй том бүсний арал, чимэглэл нь улс төр, соёлын нөлөөгөөр нүүдэлчдийн нутаг дэвсгэрт тархаж байв. Тэдгээр загварт чимэглэл нь янз бүрийн амьтдын мөргөлдөөн, сөргөлдөөний дүр зураг, түүний дотор домгийн амьтад, хүмүүс, сүйх тэрэг гэх мэт дүрсээр чимэглэдэг онцлогтой.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулсан археологийн малталт судалгаагаар хүннүчүүдийн урлагийг илтгэх сонирхол татахуйц олон олдвор хэрэглэгдэхүүн нэг бус илэрч, судалгааны эргэлтэд орсоор байгаа. Үүний нэг нь тэдний дүрслэх урлагийн өвөрмөц төрөл болох зураасан зураг юм. Зураасан зургийг Хүннү нар үйсэн сав (Төрбат 2001), ясан эдлэл (Эгиймаа 2003; Төрбат нар 2008), нумын ясан наалт (Наваан 2002; Амгалантөгс, Амартүвшин 2011), бүсний арал (Хүннүгийн... 2011: зур. 173, 174) хад чулуу (Цэвээндорж нар 2010) зэрэг дээр ихэвчлэн ан амьтан, түүнийг авлаж буй анчин, сүйх тэрэг, эд юмс, хээ, угалз зэргийг нарийн хурц үзүүртэй зүйлээр сийлбэрлэсэн байдаг.

Бид 2023 онд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Их Сансар ууланд малтсан Хүннүгийн жирийн иргэдийн 1-р булшнаас богхед бүсний арал илрүүлсэн юм. Уг бүсний арал дээр зураасан зургийн аргаар 3 амьтны дүрс сийлсэн байна.

Энэ өгүүлэлд уг олдворыг танилцуулж, судалгааны эргэлтэд оруулж, тус арал дээр дүрсэлсэн зураасан зургийн утга, бэлгэдлийн талаар санал, таамгийг дэвшүүлэхийг зорив.

¹ МУИС, ШУС, Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхим,

Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

² Соёлын өвийн үндэсний төв


³ МУИС, ШУС, Түүхийн тэнхим

* Холбоо барих зохиогч: mijiddorj.e@num.edu.mn


Их Сансар уулын “Хар чулуут”-ын хүннүгийн оршуулгын газар

Говьсүмбэр аймгийн төв Чойроос зүүн тийш 18 км зайд орших Их Сансар хэмээх оройдод хадтай, алсын бараатай, сондгой уулын ойр орчимд хиргисүүр, дөрвөлжин булш, хүннү булш, монгол булш зэрэг олон үеийн дурсгалтай (Зураг 1, 2). Эндхийн хүннүгийн бэсрэг оршуулгын газрыг Говьсүмбэр аймгийн “Боржигин өв” музейн ажилтнууд 2021 онд илрүүлэн анхны бүртгэл хийсэн байна. Тэд энд нийт хүннүгийн 28 булш бүртгэсэн бөгөөд үерийн усанд идэгдэн, жалганы нуралтад өртсөн 4 дурсгалыг яаралтай авран хамгаалах шаардлагатай байгааг холбогдох судалгааны байгууллагуудад мэдэгдсэн нь бидний энэхүү судалгааны ажлын эхлэл болсон билээ. Уг дурсгалт газар МУИС-ийн археологийн судалгааны баг 2023 оны намар хүннүгийн жирийн иргэдийн нийт 34 булш бүртгэж, эрсдэлд орсон дөрвөн булшийг малтан судалсан юм (Мижиддорж нар 2023; 2023б). Уг хүннүгийн жирийн иргэдийн оршуулгын газар нь Их Сансар уулын баруун урд бэлд байх бөгөөд зүүн хойноос баруун урагш 260 гаруй метр сунаж тогтсон, дундуураа жалгатай, жалганы баруун хэсэгт 13, зүүн хэсэгт 21 булш байна. Нутгийн иргэд энэ газрыг мөн “Хар чулуут” хэмээн нэрлэдэг байна. Ихэнх булшны чулуун дараас тодорхой мэдэгдэж байгаа бол зарим булшны чулуун дараас элс, шороонд дарагдсан байдалтай байв. Эндхийн булшнаас бид 4 булш малтан судалснаас 1-р булшнаас өгүүлэн буй зураасан зургийн дүрслэл бүхий олдвор илэрсэн юм (Зураг 4).


1-р булш. Уг булш нь тус дурсгалт газрын хамгийн хойд талд байх ба уулын амны ус урсаж жалганы ирмэгт (N 46°23'38.1" E 108°37'06.0", Alt 1488 m) байрлаж байсан нь үерийн усанд идэгдэж чулуун дараасны зүүн хойд хэсэг үлдэж бусад хэсэг нь нурж зохион байгуулалтаа алджээ (Зураг 3). Газрын



Зураг 1. Их Сансар уулын дурсгалт газрын байршил



Зураг 2. Их Сансар уулын дурсгалт газрын агаараас авсан зураг



Зураг 3. 1-р булшны гэрэл болон малтлагын гар зураг

хөрснөөс доош жалганы ёроолын түвшин хүртэл 1,5 м гүн нуруулт үүсэж булшны чигжээс чулууд ил гарсан байдалтай байна. Илт мэдэгдэж байгаа чигжээс чулуудыг цэвэрлэн булшны нүхний толбыг илрүүлэх зорилготой малтлагын ажлыг эхлүүлсэн. Булшны гүн 2,6 м болоход нүхний толбо мэдэгдэж эхлэн цааш хөөн малтахад 3,8 м гүнд нүхний толбо 210×190 см хэмжээтэй тодорхой болов. Энэ үед булшны нүхний зүүн талаас авсны модны үлдэгдэл, төв хэсгээс малын толгойн ясны хэсэг, ваарны хагархай, төмрийн үлдэгдэл зэрэг илэрсэн. Цааш үргэлжлүүлэн 40 см гүнтэй нэг үе малтахад оршуулгын нүхний зүүн урд, зүүн хойд хэсгээс авсны модон хэсгүүд нэмж илэрлээ. Мөн нүхний төв хэсэгт бог малын дунд чөмөг, эрүүний яс гарав. Малтлагын гүн 4,2 м.

Оршуулгын нүхний байдлаас харахад хүнээ зүүн хойд зүг хандуулан тавьжээ. Малтлагын гүн 5 м болоход модон австай оршуулга илрэв. Авсны мэдэгдэж байгаа хэмжээ хөл талдаа 40 см, толгой талдаа 70 см, урт нь тахилын хэсгийн хамт 2,6 м, авсны өндөр хамгийн сайн мэдэгдэж байгаа хөл талдаа 40 см байв. Уг булшны толгой болон цээж хэсгийг тонуулчид эмх замбараагүй болгосон бол аарцаг, доод мөчдийн яс анхны байрлалаараа байв (Зураг 4). Талийгаачийн бүсэлхий орчмоос хос дөрвөлжин бүсний арал илэрсэн нь хадгалалт сайн богхед¹ байна (Зураг 4.1). Булшнаас хүрэл сумны зэв, хазаарын хүрэл унжлага, хөндий хүрэл эдлэл, үелж зассан шилэн чимэглэл, амьтны дүрстэй хүрэл эдлэл, хүрэл товруу, хээтэй ясан эдлэл, үйсэн савны ёроол, үйсэн эдлэл, чий будагтай эдлэлийн хэсэг, даавуун


эдлэлийн үлдэгдэл, төмөр сэлэмний хэсгүүд, төмөр зэв болон шавар ваар, төмөр эдлэл, модон эдлэлийн хэсгүүд илэрч олдлоо. Булшнаас илэрсэн хүний ясны байдлаас харахад эрүүний М3 хараахан ургаагүй, сүүжний яс болон дунд чөмөг, эрүү зэргээс харахад 20 орчим насны эрэгтэй хүн болох нь тодорхой байна.

Бүсний арал: 1-р булшнаас анхны байрлал дээрээ буюу талийгаачийн хэвлий хэсгээс хадгалалт сайтай, хос богхед бүсний арал илэрсэн юм. Уг хос бүсний арал нь хэлбэр хийц загвар ижил, урд буюу толин талдаа хөндлөн 5 эгнээ 4, 3, 4, 3, 4 гэсэн байдлаар чулуун шигтгээгээр чимэглэхдээ эхний эгнээ ногоон, дараагийн эгнээ улаан гэсэн дарааллаар шигтгэжээ. Уг хос бүсний арлыг анх олдсон байдлаар нь баруун (урт 145,5 мм, өргөн 93 мм), зүүн (урт 151,8 мм, өргөн 92,7 мм) хэмээн авч үзсэн бөгөөд баруун бүсний арал дотор талдаа зураасан зургийн дүрслэлтэй байна (Зураг 5, 6).


Баруун бүсний арлын дотор талд хурц үзүүртэй зүйлээр нарийн зураас гаргаж гурван амьтныг дүрсэлжээ. Эдгээрийг товч тодорхойлбол (Хүснэгт 1).

Ийм төрлийн бүсний арал Монгол болон хөрш бүс нутагт малтсан хүннү булшнаас нэг бус удаа олдож байжээ. Тодруулбал, 1968 онд Шинэ Дархан хотын ойролцоо Салхит өртөө орчимд эвдэгдсэн хүннү булшнаас эрдэнийн чулуун шигтгээтэй, сийлмэл хээтэй, дөрвөл тал ирмэгийг мөлийлгөн зүлгэсэн, хоёр талдаа жижиг дугуй нүхтэй зэрэг харилцан адилгүй хэмжээтэй богхед бүсний арал 4 ш (Пэрлээ 2012: 146), Увс аймгийн Тэс сумын Хүрэн толгойгоос хос богхед бүсний арал тус тус олдсон байна. Харин бүс нутгийн хэмжээнд Хакасын Калы, Хятадын Даодуньцзы, Өмнөд Казахстаны Жаман-Тогай, Буриадын Ивлэгийн суурин (Давыдова 1995: табл. 157), Тувагийн Ала-Тэй 1, Терезин, Хятадын Шинжаан зэрэг газраас богхедоор

¹ “Богхед” буюу гаат нь эрдэс мэт харагддаг боловч үнэндээ нүүрсний нэгэн төрлийн чулуулаг, органик гаралтай хагас эрдэнийн чулуу юм. Энэ нь эртний модны үлдэгдэл удаан хугацаанд өндөр даралт, хүчилтөрөгчийн хомс нөхцөлд нүүрсжих явцад бий болдог.




Зураг 4. 1-р булшны орицуулгын хэсгийн гар зураг, богхед бүсний арал



Зураг 5. Богхед бүсний арал (хос)

Хүснэгт 1. Бүсний арал дээрх зураасан зургийн дүрслэлийн тодорхойлолт

№	Дүрслэл	Тодорхойлолт
1		Гурван салаа эвэртэй, том чихтэй, нүд, хамрын нүх, ам, сүүл зэргийг мэдэгдэхүйц, хүзүү болон биеийг нарийхан гуалиг байдлаар дүрсэлсэн бол дөрвөн хөлийг мөн нарийхан давхиж байгаа байдлаар явдал дунд нь дүрсэлжээ.
2		Бугын араас том биетэй, урт чихтэй, хурц нүдтэй, хамрын хониоорыг мэдэгдэхүйц, амаа ангайсан хөл биеийг гэтсэн байдалтай араатныг (чоно бололтой) дүрсэлсэн байх бөгөөд нарийн урт унжсан сүүлтэйгээр уг араатныг бүтнээр нь дүрсэлсэн байна.
3		Өмнөх араатны хойд дээд талд мөн нэг араатныг хурц нүдтэй, хониоор, жимийсэн амтай, том чихтэй толгойтой, хүзүү, нуруу зооны дээд дүрслээд бусад хэсгийг нь зуралгүй орхисон эсвэл хэрэглээний явцад арилсан байж ч болно.



Зураг 6. Богхед бүсний арлын гар зураг (баруун талын бүсний арал)

урласан бүсний арал илэрч байжээ (Килуновская, Леус 2020: рис 1).

Төв Азиас илэрсэн ийм төрлийн ихэнх бүсний арлууд нь цэрэг эрсийн булшнаас олдсон байх бөгөөд НТӨ II-I зууны үед хамаарч байна. Евразийн олон ард түмний хувьд бүс нь үндэс угсаа, овог аймаг, нийгэмд эзлэх байр суурийг илтгэх маш чухал үүрэг бүхий хувцасны хэсэг юм. Нүүдэлчдийн язгууртнууд нь ихэвчлэн Хятад эсвэл Төв Азийн хотууд дахь уран дархны газруудад ашигладаг үнэт металлаар хийсэн урлагийн өндөр чанартай бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой байсан бол харин жирийн иргэд нь хүрэл болон бусад материал (яс, эвэр, мод, чулуу гэх мэт)-аар хийсэн илүү хямд үнэтэй эд зүйлсийг хэрэглэж байсан нь археологийн олдвороос тодорхой харагддаг.

Бидний илрүүлсэн богхед бүсний арал нь орон нутгийн урчуудын бүтээл байх магадлалтай бөгөөд зураасан зураг бүхий ийм бүсний арлууд нь ерөнхийдөө шигтгээтэй, хэлбэр, хэмжээгээрээ адилсдаг. Зураасан зургууд нь ялангуяа энэ үед холбогдох хүрэл бүсний арлууд дээрх уран сайхны өндөр мэдрэмжтэй дүрслэлтэй харьцуулахад энгийн байдалтай зурагдсан нь анхаарал татаж байна.

Амьтны ийм энгийн дүрслэлтэй бүсний арал нь Өвөр Байгал, Өмнөд Казахстан, Шинжаанаас тус тус илэрчээ. Эдгээрийн дотроос Шинжаанаас олдсон бүсний арал дээр бие бие рүүгээ алхаж буй хоёр бугын дүрс байх бөгөөд буланд нь доош бөхийсөн хөлтэй домгийн амьтныг дүрсэлсэн нь Их Сансар уулын 1-р булшны бүсний арал дээрх зураасан зургийн дүрслэлийн агуулгатай дүйж байна (Зураг 3, 4). Судлаачид энэхүү Шинжаанаас олдсон бүсний арал дээрх дүрслэлд домгийн амьтан нь чоно (?), туурайтай, магадгүй ар нуруундаа далавчтай нь Ираны домогт гардаг Симург шувууны дүрийг санагдуулам болохыг тэмдэглэжээ (Takahama 1997: 133, 285).


Их Сансар уулын 1-р булшаас олдсон бүсний арал дээрх зураасан зургийн дүрслэлтэй төстэй олдвор Казахстан дахь Жаман-Тогайн дурсгалт газрын 21-р булшнаас илэрчээ (Максимова и др. 1968: 186-188). Тэрхүү дүрслэлд бугын ам, эвэр, хагас нугалсан хөл дүрслэгдсэн байх бөгөөд зургийг бүрэн дуусаагүй мэт харагдаж байгаа нь, Их Сансар уулын 1-р булшнаас олдсон бүсний арлын 3-р дүрслэлд байгаа араатныг “урлаач” нь арлын дотор талын гадаргуу дээр нэгэн жигд цэгцтэй оруулахыг хичээгээгүй эсвэл чадаагүй дутуу орхисонтой адил төстэй байна (Зураг 7).

Их Сансар уулын хүннүгийн жирийн иргэдийн 1-р булшнаас илрүүлсэн богхед бүсний арлаас дээж авч 2024 онд Япон улсын Токио хотын Мэйжи их сургуулийн материал судлалын лаборатори, Соёлын өвийн үндэсний төвийн мэргэжилтнүүд хамтран олдворын материал, төрөл зүйн судалгааг байгалийн шинжлэлийн аргаар хийж байна.

Дүгнэлт

Их Сансар уулын хүннүгийн жирийн иргэдийн 1-р булшнаас илэрсэн богхед бүсний арлын дотор талд дүрсэлсэн амьтны дүрслэл нь бусад ижил төрлийн олдвороос ялгарах гол онцлог нь нэг талбайд зэрэгцүүлэн болхи байдлаар дүрсэлсэн байна. Эдгээр амьтдын дотор бугын эвэр, чих, туурай зэргийг дүрсэлсэн байдал нь бусад зураасан зургийн ижил төрлийн олдвортой адилхан байна. Энэ нь тухайн амьтныг дүрслэх нийтлэг ойлголт байсныг харуулна.

НТӨ II-I зууны үед холбогдох хүннүгийн жирийн иргэдийн булшнаас богхед бүсний арал цөөнгүй олдсон нь ийм төрлийн бүсний арлыг энгийн дайчид түгээмэл ашиглаж байсныг илтгэнэ. Энэ нь дайчин эрийн ангийн олз омог, дайн тулааны ялалтыг бэлгэдэж, цаашлаад цэргийн албан тушаал, овгийн бэлгэдэл зэргийг илэрхийлж байгаа бололтой.



Зураг 7. Хүннугийн зураасан зургийн дүрслэл бүхий богхед бүсний арлууд:
 1. Жаман-Тогай, Өмнөд Казахстан, 2. Иволгын суурин, Буриад, ОХУ, 3. Шинжаан, БНХАУ,
 4. Их Сансар уул, Монгол Улс

Abstract**New scratched images discovery of the Xiongnu: Preliminary results from archaeological research at Ikh Sansar Mountain, Gobi Sumber aimag****Enkhbayar Mijiddorj, Ganbold Ankhsanaa and Baatar Galbadrakh**

This article includes the research of 3 creatures drawn by sharp-edged tools making narrow lines inside belt plaque which was found from the first burial of Khar Chuluut in Ikh Sansar mountain, Sumber soum, Gobi Sumber aimag. This drawing may symbolize a warrior's spoils of war, reward, and victory, and represents military rank and clan symbols.

Keywords: Xiongnu burials, boghead, belt plaque, line drawing

Ном зүй

Амгалантөгс. Ц., Амартүвшин, Ч. (2011). Нумын наалтан дээрх сараачмал хэдэн дүрс (Хүннү булшны хэрэглэгдэхүүнээр). *Studia Archaeologica*. Tom. (III) XXIII, Fasc.5. УБ.

Давыдова А. В. (1995). Иволгинский археологический комплекс. Т. 1: Иволгинское городище. Фонд «АзиатИКА», 1995 (Археологические памятники сюнну; Вып. 1). СПб.

Килуновская, М. Е. Леус, П. М. (2020). Пряжки из сибирского гагата в погребениях эпохи хунну II–I вв. до н. э. в Туве. - *Археологические вести*. 2020. Вып. 30. Санкт-Петербург.

Максимова А.Г., Мершиев М.С., Вайнберг Б.И., Левина Л.М., (1968). Древности Чардары (археологические исследования в зоне Чардаринского водохранилища). Алма-Ата.

Мижиддорж Э., Галбадрах Б., Анхсанаа Г., Өнөрбаяр Б., Эрдэнэбат О., Цэндбаяр Б. (2023). Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дахь Их Сансар уулын Хар чулуут, Хар өндөр уулын хөтөлд явуулсан археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлын тайлан. УБ.

Мижиддорж Э., Галбадрах Б., Өнөрбаяр Б., Эрдэнэбат О., Цэндбаяр Б. (2023). Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын “Их Сансар уул”-ын авран хамгаалах судалгаа. Монголын археологи-2023. УБ. 2023: 42-45.

Наваан Д. (2002). Хүннүгийн ховор сонин олдвор. Монгол Улсын их сургууль. Нийгмийн ухааны факультет. Археологи, антропологи, угсаатаны судлал. Эрдэм шинжилгээний бичиг №187 (13). УБ.

Пэрлээ, Д. (2012). Монголын түүх судлах сурвалжийн нэгэн нь пайз мөн. Д.Пэрлээ Бүтээлийн чуулган. IV боть: Эрдэм шинжилгээний өгүүлэл (1964–1982 он). УБ.

Төрбат, Ц. (2001). Хүннүгийн булшнаас гарсан үйлсэн дээрх тэргэний зураг. Улсын багшийн их сургууль. Нийгмийн Ухааны Факультет. Эрдэм шинжилгээний бичиг. Tomus II, Fasc. 2. УБ.

Төрбат, Ц. Батсүх, Д., Пуса, Н., Рамзайер, Д. (2008). Хүннүгийн үеийн Бороогийн сууринд хийсэн судалгаа. Талын их эзэнт гүрэн- Хүннү. Монгол-Солонгосын хамтарсан судалгааны 10 жилийн ойн симпозиум. УБ.

Хүннүгийн өв, (2011). Нүүдэлчдийн анхны төр-Хүннү гүрний соёл. Эмхэтгэн нийтлүүлсэн Г.Эрэгзэн. УБ.

Цэвээндорж, Д., Кубарев, В.Д., Якобсон, Э. (2010). Шивээт хайрханы хадны зураг. УБ.

Эгиймаа, Ц. (2003). Хүннүгийн зураасан зургийн дурсгал. – *Studia Archaeologica*. Tom. I (XXI), Fasc.7. УБ.

Mijiddorj, E. (2024). “Preliminary results of the excavation of hunnu burials at “ikh sansar uul”. // Interactions between the Central Plains and the Grasslands: International Symposium on New Discoveries and New Research in Xiongnu Archaeology Manual. China, Zhengzhou. 2024.01.08-11.

Takahama, Shu. (1997). Daisogen no kiba minzoku — Chûgoku hoppô seidôki 大草原の騎馬民族—中国北方青銅器 [Mounted Nomads of the Asian Steppe — Chinese Northern Bronzes]. Tokyo: Tokyo National Museum.

Received: Nov. 16, 2025; Revised: Dec. 8, 2025; Accepted: Dec. 18, 2025

